

Түүх 6: Мосе 3

Библийн эшлэл
[Гэтлэл 14:13]

Мосе ард түмэнд – Бүү ай! Бат зогсож, ЭЗЭНий чөлөөлөхийг харцгаа.
Тэр өнөөдөр та нарын төлөө үүнийг гүйцээх болно. Учир нь өнөөдөр та нарын харж
байгаа египетчүүдийг та нар дахин хэзээ ч харахгүй.

Мосе, Израиль ард түмэнтэй хамт Канааныг зорьсон уртаас урт аялалыг эхлүүлэв.

Бурхан Израиль ард түмэнд зориулан өдөр нь үүлэн баганаар нарын хурц туяанаас хамгаалж,
шөнө нь галан баганаар тэдний замыг гэрэлтүүлж байлаа.

Гэтэл тэд замдаа явсаар маш том тэнгисийн эрэг дээр ирээд гацав. Харин Мосе асар майхан барьж хүмүүсийг амраахаар болов.
Гэтэл нөгөө талд Израиль ард түмнийг явуулсан Фараон хаан харамсаж байв. Тийм болхоор Фараон хаан
шийдвэр гаргаж цэргүүдээ морин тэрэгтээ суулгаж тэдний хойноос харвасан сүм шиг явав.

Израиль ард түмэн газар сууцгаан амарцгааж байтал цөл талын тээр холоос Египетийн цэргүүд ирж байгааг харав.
Гэтэл тэд Египет цэргүүд дайран ирж байгааг хараад айж эмээсэндээ Мосед гомдоллож эхлэв.

Харин Мосе ард түмэнд ингэж хэлэв. “Бүү айгтун. Бурхан биднийг энэ байдлаас зайлшгүй аврах болно.” гэв.
Энэ үед Египетийн цэргүүд улам дөхөн ирж байлаа. Бурхан Мосед айлдав.

“Мосе, чи ард түмнийг дагуулан улаан тэнгисийг гатал! Чи өөрийнхөө таягыг өргөн далай дээгүүр сунга.
Тэгвэл далай хоёр хуваагдаж, Израильчуудын хөлөнд ус хүрэхгүйгээр гатлах болно.”

Мосе, Бурханы хэлсний дагуу далай руу таяг аа чиглүүлэн сунгав.

Тэгмэгц хаанаас ч юм хүчтэй салхилан салхилсаар далайн усыг хоёр хэсэгт хувааж, хуурай газрыг ил гаргалаа.
Ус хоёр хэсэгт хана мэт хуваагдан хуурай зам гаргажээ. Ийнхүү Израильчууд бүгд эсэн мэнд гаталж чаджээ.

Египетийн цэргүүд ч ойртон ирж тэдний араас далайн дундах хуурай зам уруу орцгоов.

Энэ үед Мосе гараа далай руу чиглүүлэн өргөв. Гэтэл хуваагдсан байсан далайн ус хүмигдан буцаж хэвэндээ орж эхлэв.
Харин Египет цэргүүд уснаас зугтан гарах гэж оролдов.

Гэвч Бурхан Египетчүүдийг далай дунд хаясан юм.


Израиль ард түмэн бүгд Бурханд талархал өргөв. Бас тэд Бурхан болон Мосед итгэцгээжээ.

Ингэж Мосе Израильчуудыг Бурханы амлалтын газар болох Канаан нутаг уруу удирдахаар дуудагдсан хүн болохоо
харуулсан юм.



Үйл ажиллагаа 1.

Өнгийн цаасыг “Улаан тэнгис” дээр нааж Мосе болон ард түмнийг хайчлан авч хуурай газар наагаарай. (Хэрэглэгдэх материал: Өнгийн цаас, хайч, цавуу)



- Дараах эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Гэтлэл 14:13)

ЭЗЭНий чөлөөлөхийг харцгаа.

